

|  |   |   |
|--|---|---|
| БАТЛАВ:<br>ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,<br>ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД<br>..... | БАТЛАВ:<br>ГАДААД ХАРИЛЦААНЫ<br>САЙД<br>..... | БАТЛАВ:<br>ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД<br>ХЭРГИЙН САЙД<br>..... |
| Ч.УЛААН  | Д.ЦОГТБААТАР                                  | Ц.НЯМДОРЖ   |

## ХУДАЛДААНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэж заасан нь төрийн эдийн засгийн бодлогын суурь зарчим юм.

Монгол Улсын худалдааг хөнгөвчлөх, дэмжих, хөгжүүлэх, Дэлхийн худалдааны байгууллагын өмнө хүлээсэн үүрэг амлалтыг хэрэгжүүлэх, харилцааг хуулиар зохицуулах дараах хууль зүйн үндэслэл, практик шаардлага байна.

### 1.1. Хууль зүйн үндэслэл

Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ийн 7 дугаар зорилтын 2.1.7-д “Худалдаа, үйлчилгээг хөнгөвчлөх, экспорт, импортын барааны тээвэрлэлтийн ложистик сүлжээг хөгжүүлэх, тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог хялбаршуулах, татвар төлөлтийн болон улсын бүртгэлийн тогтолцоог цахимжуулж, боловсронгуй болгон бизнес эрхлэлтийн орчныг төгөлдөршүүлнэ” ;

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.48.8-д “..... Худалдааны салбарын эрх зүйн орчныг бүрдүүлнэ”;

Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 184-т “Худалдааны тухай хуулийн төслийг шинээр боловсруулах ингэхдээ Худалдааг зохицуулсан бие даасан хууль байхгүй бөгөөд гадаад, дотоод худалдааны эрх зүйн орчинг бүрдүүлэх замаар худалдааны үр ашгийг нэмэгдүүлэх, худалдаа эрхлэгчдийн болон худалдан авагчийн ашиг сонирхлыг хамгаална” гэж заасан.

### 1.2. Практик шаардлага

Монгол Улсын худалдааны харилцааг эрх зүйн хүрээнд 57 хуулийн 100 гаруй зүйл заалтаар хэсэгчлэн зохицуулж байна.

Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн тулгуур болсон худалдааны салбар нь 2018 оны байдлаар ДНБ-ны 17 орчим хувь, идэвхитэй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн 40 орчим хувийг бүрдүүлж, 200 гаруй мянган хүнийг ажлын байраар тогтвортой хангаж байна.

Хэдийгээр Монгол Улсын эдийн засагт худалдааны салбарын гүйцэтгэх үүрэг

улам бүр өсөн нэмэгдэж байгаа ч худалдааг зохицуулах тусгайлсан хууль, салбар дундын уялдааг хангасан нэгдсэн бодлогын баримт бичиг байхгүй байна.

Үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн бодлого хөтөлбөрүүд хэрэгжиж, үйлдвэрлэлийн хүчин чадал олон улсад өрсөлдөх хэмжээнд хүрч байгаа ч дотоодын үйлдвэрлэлийг худалдаагаар дэмжих бодлого зохицуулалтгүйгээс өрсөлдөх чадвар сул, хөгжих боломж хязгаарлагдмал байна.

Монгол Улсын гадаад орнуудтай харилцан ашигтай худалдаа хийх, үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, шударга бус өрсөлдөөнөөс хамгаалах, улмаар эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөө, үр ашгийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Худалдааны салбарын хөгжлийн нэгдсэн бодлогыг дэлхийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн нэгтгэн зангидах чиг үүрэг бүхий оновчтой тогтолцоогүй, салбарын статистик тоон үзүүлэлт хангалтгүй, мэдээллийн нэгдсэн сан бүрдээгүй байна.

Иймд дээр дурьдсан хууль зүйн үндэслэл, практик шаардлагын дагуу Монгол Улсын Худалдааны тухай хуулийн төслийг боловсруулна.

Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Монгол Улсын худалдааны эрх зүйн орчинг бүрдүүлэхээр Худалдааны тухай хуулийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн 22.1.1 дэх заалтыг үндэслэн анхдагч хуулийн төсөл хэлбэрээр боловсруулна.

Энэ хуулийн төсөл нь ..... бүлэг ..... зүйл ..... заалтаас бүрдэнэ.

Энэ хуулийн төсөлд Монгол Улсын худалдааг бүтцийн хувьд гадаад, дотоод болон тусгай дэглэмийн, төрлийн хувьд бараа, үйлчилгээ болон оюуны өмчийн эрхийн худалдаа гэж тодорхойлох бөгөөд хуулийн төсөл нь барааны худалдаа болон энэ хуульд заасан үйлчилгээний худалдаанд хамаарна.

Гадаад худалдааг эрхлэгч этгээд, гадаад худалдаа эрхлэхэд тавигдах нийтлэг шаардлага, эрх үүргийг тодорхой болгох замаар хариуцлагын тогтолцоог бий болгох, гадаад худалдааны төлбөр тооцоо, төрөөс гадаад худалдааг тарифын болон тарифын бус аргаар зохицуулах арга механизмыг тодорхойлно.

Дотоод худалдааг бөөний болон жижиглэн худалдаа эрхлэх нийтлэг шаардлага, хэрэглээний явцад чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй нь тогтоогдсон болон оюуны өмчийн эрхийн зөрчилтэй барааг зах зээлээс эргүүлэн татах асуудлыг тусгана.

Тусгай дэглэмийн худалдааг хэлбэрийн хувьд чөлөөт бүсийн болон хил орчмын худалдаа, чөлөөт бүсийн худалдааг тусгайлсан хуулиар зохицуулахаар, хил орчмын худалдааг хөрш зэргэлдээ улстай олон улсын хэм хэмжээнд нийцүүлэн харилцан тохиролцож байгуулсан гэрээний дагуу тухайн бүс нутгийн хилийн боомтын бүс нутагт зохион байгуулахаар тусгана.

Худалдаа эрхлэгчийн эрх, үүргийг тодорхойлж тусгана.

Төрийн байгууллагын бүрэн эрх, төрийн бус байгууллагын оролцоог тодорхойлж, төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай зохицуулалтыг тусгана.

Худалдааг дэмжих, хөнгөвчлөх зохицуулалтыг тусгана.

Монгол Улсын худалдааны бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим санг бий болгох, бүрдүүлэх, ашиглах тухай тусгана.

Түүнчлэн худалдаанд тавих төрийн хяналт, худалдааны хууль тогтоомжийг зөрчигчид хүлээлгэх хариуцлагатай холбогдсон харилцааг тусгана.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох хууль эрх зүй, нийгэм, эдийн засгийн үр дагавар

Энэхүү хууль батлагдснаар нийгэм эдийн засаг, хууль зүйн дараахь үр дагавар гарна:

1. Монгол Улсын худалдааны бүтэц, төрөл, хэлбэр, аргыг тодорхойлох, худалдаатай холбогдсон ойлголтыг нэр томъёожуулах, гадаад болон дотоод худалдааг эрхлэхэд тавигдах нийтлэг шаардлага, төрийн байгууллагын бүрэн эрх, төрийн бус байгууллагын оролцоо, худалдаа эрхлэгчийн эрх үүрэг, худалдааг дэмжих, хөнгөвчлөх, худалдааны бүртгэл, хяналт, хариуцлагын тогтолцоо бүрдэнэ.

2. Гадаад, дотоод худалдааны уялдаа холбоо сайжирна.

3. Худалдааны эрх зүйн орчин бий болсноор эдийн засгийн өсөлт нэмэгдэх, тогтвортой хөгжлийг хангах нөхцлийг бүрдүүлнэ.

4. Худалдааны харилцаанд оролцогчдын эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчин бүрдэнэ.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар:

Энэхүү хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд нийцүүлэн боловсруулах болно.

Худалдааны тухай хуулийг батлуулж, хэрэгжүүлэхэд Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Статистикийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль гэх мэт холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулна.

---oo0oo---

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны .. дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

## ХУДАЛДААНЫ ТУХАЙ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### *1 дүгээр зүйл.Хуулийн зорилт*

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын худалдаанд тавих шаардлага, худалдаа эрхлэгчийн эрх, үүргийг тодорхойлж, худалдааг төрөөс дэмжих, хөнгөвчлөх, зохицуулах, хамгаалах, төрийн бус байгууллагын оролцоог хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### *2 дугаар зүйл.Худалдааны тухай хууль тогтоомж*

2.1.Худалдааны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Иргэний хууль<sup>2</sup>, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

#### *3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ*

3.1.Энэ хууль иргэн, хуулийн этгээдийн эрхлэх барааны худалдаатай холбогдсон харилцаанд хамаарна.

3.2.Батлан хамгаалах, тагнуул, цагдаагийн байгууллага, тэдгээрийн гүйцэтгэх ажиллагааны зориулалттай барааг худалдахтай холбогдсон харилцаанд энэ хууль хамаарахгүй.

3.3.Цахим, шууд, дистрибьютер, оюуны өмчийн эрхийн, биржийн болон үйлчилгээний худалдаатай холбогдсон харилцааг тусдаа хуулиар зохицуулна.

3.4.Барааг арилжих, тээвэрлэхтэй холбогдсон харилцааг Иргэний хууль, Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн биржийн тухай<sup>3</sup>, Гаалийн тухай, Авто тээврийн тухай, Төмөр замын тээврийн тухай, Усан замын тээврийн тухай хууль болон холбогдох бусад хуулиар зохицуулна.

3.5.Худалдаатай холбогдох өрсөлдөөн, хэрэглэгчийн эрх, даатгалын асуудлыг Өрсөлдөөний тухай, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай, Даатгалын тухай хуулиар зохицуулна.

#### *4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт*

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль -"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

<sup>2</sup> Иргэний хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

<sup>3</sup> Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн биржийн тухай -"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

4.1.1. "худалдаа" гэж бараа, үйлчилгээ, оюуны өмчийн эрхийг худалдах, худалдан авах үйл ажиллагааг;

4.1.2. "бараа" гэж худалдах, худалдан авах, арилжих зориулалттай, үнэ бүхий хөдлөх эд хөрөнгийг;

4.1.3. "стратегийн бараа" гэж Хүнсний тухай хуулийн 3.1.6 дахь хэсэгт тусгасан бараа болон ..... барааг хамааруулна

4.1.4. "гадаад худалдаа" гэж Монгол Улс, гадаад улсын хооронд улсын хил дамжин хийгдэж байгаа худалдааг;

4.1.5. "дотоод худалдаа" гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт хийгдэж буй-байгаа худалдааг;

4.1.6. "тусгай дэглэм" гэж хуулиар болон төрийн эрх бүхий байгууллагаас тусгайлан тогтоосон тодорхой нутаг дэвсгэрт үйлчилж байгаа худалдааны зохицуулалтыг;

4.1.7. "хил орчмын худалдаа" гэж Монгол Улсын Засгийн газар, хөрш улсын Засгийн газар хооронд байгуулсан гэрээг үндэслэн хил орчмын нутаг дэвсгэрт хийх худалдааг;

4.1.8. "экспорт" гэж гадаад улсын нутаг дэвсгэрт худалдах болон бусад зорилгоор Монгол Улсын нутаг дэвсгэрээс бараа гаргахыг;

4.1.9. "импорт" гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт худалдах болон бусад зорилгоор гадаад улсын нутаг дэвсгэрээс бараа оруулахыг;

4.1.10. "реэкспорт" гэж гадаадын барааг гаалийн хууль тогтоомжийн дагуу хилийн чанадад буцаан гаргахыг;

4.1.11. "реимпорт" гэж хилийн чанадад гаргасан барааг гаалийн хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулахыг;

4.1.12. "дэмпинг" гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт импортоор оруулж байгаа барааны үнэ экспортлогч орны зах зээлийн үнээс доогуур байхыг;

4.1.13. "импортын барааны хэт өсөлт" гэж импортын барааны их хэмжээний нийлүүлэлт дотоодын ижил төрлийн барааны үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлсөн, ноцтой хохирол учруулахуйц байдал үүссэн, хохирол учруулсныг;

4.1.14. "худалдаа эрхлэгч" гэж ашиг олох, хэрэглэгчийн эрэлт, хэрэгцээг хангах зорилгоор худалдаа эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийг;

4.1.15. "жижиглэн худалдаа" гэж хэрэглэгчийн хэрэгцээнд зориулан барааг худалдах, худалдан авах үйл ажиллагааг;

4.1.16. "үүргийн худалдаа" гэж хэрэглэгчид ойртуулан худалдааны түр газарт хийгдэх жижиглэн худалдааны хэлбэрийг;

4.1.17. "бөөний худалдаа" гэж үйлдвэрлэл, жижиглэн худалдааны зориулалтаар барааг худалдах, худалдан авах үйл ажиллагааг;

4.1.18. "нийлүүлэлт, борлуулалтын сүлжээ" гэж нэгдсэн удирдлага, нэг стандарттай, худалдааны салбар нэгжийн хэлхээг;

4.1.19. "үл давтагдах дугаар" гэж зураасан код, түүнтэй адилтгах бусад тэмдэглэгээг;

4.1.20. "цахим нэг цонхны үйлчилгээ" гэж импорт, экспортын болон дамжин өнгөрөх барааны мэдэгдэл, холбогдох бусад баримтыг хүлээн авах гадаад худалдааны бүртгэл, хяналт, мэдээллийн нэгдсэн сүлжээг.

*5 дугаар зүйл. Монгол Улсын худалдаанд баримтлах зарчим*

5.1. Монгол Улсын худалдаанд дараахь зарчмыг баримтална:

5.1.1. Монгол Улс, олон улс, бүс нутагт зөвшөөрөгдсөн чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан байх;

5.1.2. Монгол Улсын олон улсын гэрээний дагуу үндэстний нэн тааламжтай болон үндэсний нөхцөлийг баримтлах;

5.1.3. үйлдвэрлэгч, хэрэглэгч, худалдаа эрхлэгчийн эрх ашгийг тэнцвэртэй хангах;

5.1.4. шударга өрсөлдөөнийг хангасан байх.

5.2. Монгол Улсын худалдаанд энэ хуулийн 5.1-д заасан зарчимд харшлахгүй гадаад, дотоод худалдааны хэлбэр, аргыг зөвшөөрнө.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ  
ХУДАЛДАА ЭРХЛЭГЧ, ТҮҮНИЙ НИЙТЛЭГ ЭРХ, ҮҮРЭГ**

*6 дугаар зүйл. Худалдаа эрхлэгч*

6.1. Хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын иргэн, хуулийн этгээд гадаад, дотоод худалдааг эрхэлж болно.

*7 дугаар зүйл. Худалдаа эрхлэгчийн нийтлэг эрх, үүрэг*

7.1. Худалдаа эрхлэгч дараахь нийтлэг эрхийг эдэлнэ:

7.1.1. төрөөс үзүүлэх дэмжлэгт хамрагдах;

7.1.2. зах зээлийг хамгаалуулах асуудлаар төрийн байгууллагад хүсэлт гаргах;

7.1.3. төрийн захиргааны байгууллагаас гаргасан шийдвэрийн талаар тайлбар авах, гомдол гаргах.

7.2. Худалдаа эрхлэгч дараахь нийтлэг үүргийг хүлээнэ:

7.2.1. Монгол Улсын олон улсын гэрээ, Монгол Улсын хууль тогтоомжийг биелүүлэх;

7.2.2. худалдаа эрхлэх зориулалттай, стандартын шаардлага хангасан газарт үйл ажиллагаа эрхлэх;

7.2.3. гарал үүсэл тодорхой, үл давтагдах дугаартай барааг худалдах;

7.2.4. хуульд заасан тохиолдолд тусгай зөвшөөрөл авах;

7.2.5. хүн, малын эрүүл мэнд, амьтан, ургамлын эрүүл ахуй, хүрээлэн байгаа орчинд гэм хор учруулахгүй, техникийн зохицуулалтын болон стандартын шаардлага хангасан барааг хэрэглэгчид хүргэх;

7.2.6. хэрэглэгчийг барааны талаар үнэн зөв, бодит мэдээллээр хангах;

7.2.7. дотоод хяналтыг хэрэгжүүлэх;

7.2.8. энэ хуулийн 16.1-д заасан нөхцөл үүссэн тохиолдолд мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хяналтад барааг зах зээлээс буцаан болон татан авах, түүнтэй холбогдон гарах зардлыг бүрэн хариуцах;

7.2.9. өөрийн буруутай үйл ажиллагаанаас хэрэглэгчид учруулсан хохирлыг нөхөн төлөх;

7.2.10. хуульд заасан бусад.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ ГАДААД ХУДАЛДАА

### *8 дугаар зүйл. Гадаад худалдаа эрхлэхэд тавих шаардлага*

8.1. Гадаад худалдаа эрхлэхэд дараахь шаардлагыг хангасан байна:

8.1.1. хуульд өөрөөр заагаагүй бол гадаад улсын иргэн, хуулийн этгээдтэй худалдааны гэрээ байгуулсан байх;

8.1.2. импорт, экспортын бараа нь Монгол Улс, олон улс, бүс нутгийн техникийн зохицуулалт, стандартын шаардлага хангасан байх;

8.1.3. импортын мэдэгдэл, эрх бүхий мэргэжлийн байгууллагаас олгосон гарал үүслийн болон бусад гэрчилгээтэй байх.

### *9 дүгээр зүйл. Гадаад худалдааны төлбөр тооцоо*

9.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт хийж байгаа худалдааны төлбөр тооцоо нь хууль тогтоомжид нийцсэн байна.

9.2. Гадаад худалдааны төлбөр тооцоог Монгол Улсад үйл ажиллагаа явуулах эрх бүхий банкаар дамжуулан гүйцэтгэнэ.

9.3. Экспортын барааны орлогыг тухайн барааг импортлогч хүлээн авснаас хойш 180 хоногийн дотор шилжүүлнэ.

### *10 дугаар зүйл. Гадаад худалдааг зохицуулах*

10.1. Гадаад худалдааг Монгол Улсын олон улсын гэрээ, Дэлхийн худалдааны байгууллагын хэлэлцээрийн хүрээнд дараахь аргаар зохицуулна:

10.1.1. тарифын;

10.1.2. тарифын бус.

10.2. Тарифын аргаар зохицуулалт хийхтэй холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцааг Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулиар зохицуулна.

10.3. Дараахь тохиолдолд экспорт, импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээг нэмэгдүүлж болно:

10.3.1. импортын барааны хэт өсөлт үүссэн;

10.3.2. дэмпингтэй бараа импортолсон;

10.3.3. татаастай бараа импортолсон;

10.3.4. төлбөрийн тэнцэл алдагдсан;

10.3.5. дотоодын зах зээлийг хамгаалах, үйлдвэрлэлийг дэмжих.

10.4. Засгийн газар дараахь тохиолдолд тарифын бус хязгаарлалтыг хэрэгжүүлнэ:

10.4.1. үндэсний аюулгүй байдлыг хангах, нийтийн эрх ашгийг хамгаалах;

10.4.2. байгаль орчин, амьтан, ургамлын тэнцвэрт байдлыг хангах;

10.4.3. дотоодод нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, нөхөн сэргээгдэхгүй байгалийн нөөцийг хамгаалах;

10.4.4. стратегийн барааны дотоодын зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрийг хангах;

10.4.5. Монгол Улсын гадаад валютын нөөцийн хэт бууралтыг зогсоох, тогтвортой хадгалах.

10.5. Монгол Улсын олон улсын гэрээ болон энэ хуулийн 10.4-т зааснаас бусад тохиолдолд гадаад худалдаанд тарифын бус хязгаарлалт хийхийг хориглоно.

10.6.Энэ хуулийн 10.3.1-10.3.3-т заасан тохиолдолд дотоодын үйлдвэрлэлийг шударга бус өрсөлдөөнөөс хамгаалах асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

10.7. Энэ хуулийн 10.3.4, 10.4.5-д заасан нөхцөл үүссэн тохиолдолд гадаад худалдааг хязгаарлах журмыг Монгол банк, Засгийн газар хамтран баталж, хэрэгжүүлнэ.

10.8.Дараахь тохиолдолд зарим барааны худалдааг хориглоно:

10.8.1.үндэсний аюулгүй байдал, нийтийн эрх ашигт аюул учруулах;

10.8.2.Монгол Улсын олон улсын гэрээ, Монгол Улсын хууль тогтоомжоор хориглосон;

10.8.3.Дэлхийн худалдааны байгууллагын холбогдох хэлэлцээрүүдийн хүрээнд хүлээн зөвшөөрсөн бусад тохиолдолд.

10.9.Хуульд өөрөөр заагаагүй бол Засгийн газар энэ хуулийн 10.8-д заасан шийдвэрийг худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал, мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дүгнэлтийг үндэслэн гаргана.

#### *11 дүгээр зүйл. Ачилтын өмнөх хяналт*

11.1.Дотоодын үйлдвэрийн барааны үнэд сөрөг нөлөө үзүүлэхээс урьдчилан сэргийлэх, барааны чанар, тоо хэмжээг нягтлах, хорио цээр, аюулгүй байдлыг хангах зорилгоор импортын бараанд болон хүмүүнлэгийн, буцалтгүй тусламжийн бараанд ачилтын өмнөх хяналтыг хийж болно.

11.2.Ачилтын өмнөх хяналт хийх журмыг Засгийн газар батална.

11.3.Хяналтыг Дэлхийн худалдааны байгууллагын Ачилтын өмнөх хяналт шалгалтын тухай хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлнэ.

#### *12 дугаар зүйл. Хариу арга хэмжээ*

12.1.Засгийн газар Монгол Улсын эдийн засгийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор дараахь нөхцөл үүссэн тохиолдолд хариу арга хэмжээг авах асуудлаар шийдвэр гаргана:

12.1.1.гадаад улс Монгол Улстай байгуулсан олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй;

12.1.2.Монгол Улсын эсрэг худалдааны ялгавартай хориг, хязгаарлалт, бусад арга хэрэглэсэн.

12.2.Хариу арга хэмжээ авах журмыг Засгийн газар батална. Засгийн газар хариу арга хэмжээ авахын өмнө тухайн улстай хэлэлцээ хийж болно.

### **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ДОТООД ХУДАЛДАА**

#### *13 дугаар зүйл. Дотоод худалдааны хэлбэр*

13.1.Дотоод худалдаа нь дараахь хэлбэртэй байна:

13.1.1.бөөний худалдаа;

13.1.2.жижиглэн худалдаа.

#### *14 дүгээр зүйл.Бөөний худалдаа*

14.1.Бөөний худалдаа эрхлэхэд дараахь шаардлагыг хангасан байна:



14.1.1.бөөний худалдаа эрхлэх зориулалттай, стандартын шаардлага хангасан газарт үйл ажиллагаа эрхлэх;

14.1.2.техникийн зохицуулалт, стандартын шаардлага хангасан агуулах, зориулалтын тээврийн хэрэгсэлтэй байх, эсхүл уг шаардлагыг хангасан этгээдтэй гэрээ байгуулсан байх;

14.1.3.үйлдвэрлэгч, импортлогч, жижиглэн худалдаа эрхлэгчтэй гэрээ байгуулсан байх.

14.2.Бөөний худалдаа эрхэлж байгаа газарт жижиглэн худалдаа явуулахыг хориглоно.

14.3.Бөөний худалдааг орлого, зарлагын падаан, төлбөрийн баримтаар тодорхойлно.

#### *15 дугаар зүйл. Жижиглэн худалдаа*

15.1.Жижиглэн худалдаа эрхлэх зориулалттай, стандартын шаардлага хангасан газарт жижиглэн худалдааг эрхэлнэ.

15.2.Барааг хэрэглэгчид ойртуулах, жижиглэн худалдаа эрхлэгчийг дэмжих зорилгоор үүргийн худалдааг худалдаа эрхлэх зориулалттай, стандартын шаардлага хангасан түр газарт зохион байгуулж болно.

15.3.Үүргийн худалдаатай холбогдсон харилцааг зохицуулах журмыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

15.4.Жижиглэн худалдааг эцсийн хэрэглэгчид олгосон төлбөрийн баримтаар тодорхойлно.

#### *16 дугаар зүйл. Барааг зах зээлээс буцаан болон татан авах*

16.1.Хуульд өөрөөр заагаагүй бол дараахь тохиолдолд барааг зах зээлээс буцаан болон татан авна:

16.1.1.гарал үүсэл тодорхойгүй, барааны чанар, аюулгүй байдал нь техникийн зохицуулалт, стандартын шаардлага хангаагүй нь итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээгээр тогтоогдсон;

16.1.2.сав, баглаа, боодол, шошгод тавих шаардлага хангаагүй, үл давтагдах дугааргүй;

16.1.3.оюуны өмчийн эрхийг зөрчсөн, дууриамал, хуурамч барааг худалдаагаар завдсан, худалдсан;

16.1.4.хүн, малын эрүүл мэнд, амьтан, ургамлын эрүүл ахуй, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөтэй байж болзошгүй;

16.1.5.үйлдвэрлэгч хүсэлт гаргасан.

16.2.Барааг зах зээлээс буцаан болон татан авахтай холбогдсон журмыг стандарт, мэргэжлийн хяналтын, оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.

### ТАВДУГААР БҮЛЭГ ТУСГАЙ ДЭГЛЭМ

#### *17 дугаар зүйл. Тусгай дэглэмийн төрөл*

17.1.Худалдааны тусгай дэглэм нь дараахь төрөлтэй байна:

17.1.1.чөлөөт бүсийн;

17.1.2.хил орчмын худалдааны.

17.2.Чөлөөт бүс дэх худалдаатай холбогдсон харилцааг Чөлөөт бүсийн тухай хуулиар<sup>4</sup> зохицуулна.

*18 дугаар зүйл. Хил орчмын худалдаа*

18.1.Монгол Улсын Засгийн газар, хөрш улсын Засгийн газар хооронд байгуулсан гэрээг үндэслэн хуульд өөрөөр заагаагүй бол тухайн аймгийн Засаг даргын шийдвэрээр хил орчмын худалдааг эрхэлж болно.

18.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт хил орчмын худалдаа эрхлэх журмыг Засгийн газар батална.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ ХУДАЛДААГ ДЭМЖИХ, ХӨНГӨВЧЛӨХ

*19 дүгээр зүйл. Худалдааны дэмжлэг*

19.1. Худалдаа эрхлэгчийн дараахь үйл ажиллагаанд төрөөс бодлогын болон санхүүгийн дэмжлэг үзүүлнэ:

19.1.1.гадаад улс, бүс нутаг, дотоодын зах зээлийг судлах;

19.1.2.мэргэжлийн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах;

19.1.3.экспортын бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд сурталчлах;

19.1.4.олон улсын үзэсгэлэн, яармагт оролцох;

19.1.5.дэвшилтэт техник, технологи нутагшуулах.

19.1.6.нийлүүлэлт, борлуулалтын сүлжээ байгуулах, өргөжүүлэх.

*20 дугаар зүйл. Худалдааг хөнгөвчлөх*

20.1.Худалдааг хөнгөвчлөх талаар төрийн болон төрийн бус байгууллага дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

20.1.1. худалдаатай холбогдсон хууль тогтоомж, дүрэм, журам, захиргааны шийдвэр худалдаа эрхлэгчдэд нээлттэй, ил тод байх;

20.1.2. гадаад худалдаанд цахим нэг цонхны үйлчилгээ нэвтрүүлэх;

20.2.Энэ хуулийн 20.1.2-т заасан цахим нэг цонхны үйлчилгээний журмыг худалдааны болон гаалийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

*21 дүгээр зүйл. Дамжин өнгөрөх тээвэрлэлт*

21.1.Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрээр тээврийн хэрэгсэл чөлөөтэй дамжин өнгөрөх нөхцөл боломжийг холбогдох байгууллага хангана.

21.2.Монгол Улсын гаалийн нутаг дэвсгэрт бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхэд тавих шаардлага, тэдгээрийн шилжилт, хөдөлгөөнтэй холбоотой харилцааг Гаалийн тухай хуулиар зохицуулна.

21.3.Барааг агаараар дамжин өнгөрүүлэх тээврээс бусад иргэний агаарын тээврийн олон улсын хөдөлгөөнд энэ зүйл хамаарахгүй.

21.4.Төмөр зам болон авто замаар дамжин өнгөрч байгаа худалдааны зориулалт бүхий олон улсын ачаа, барааны тээвэрлэлтийн дэд бүтцийг сайжруулж, аюулгүй байдлыг хангана.

## ДОЛООДУГААР БҮЛЭГ ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО, БҮРЭН ЭРХ

### *22 дугаар зүйл. Худалдаа, үйлчилгээний байгууллагын тогтолцоо*

22.1.Худалдаа, үйлчилгээний байгууллагын тогтолцоо нь худалдаа, үйлчилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, худалдаа, үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага түүний орон нутаг дахь газар, хэлтэс, тасаг, худалдаа, үйлчилгээний байгууллагын ажилтан, хилийн чанадад суугаа Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газрын худалдааны төлөөлөгч консулын ажилтнаас бүрдэнэ.

22.2. Худалдаа, үйлчилгээний байгууллага нь нэгдмэл тогтолцоо, төвлөрсөн удирдлагатай байна.

22.3. Худалдаа, үйлчилгээний байгууллагын орон нутаг дахь газар хэлтэс, тасаг, ажилтны үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг дарга дэмжлэг үзүүлнэ.

### *23 дугаар зүйл. Худалдаа, үйлчилгээний байгууллагын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх*

23.1.Худалдаа, үйлчилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

23.1.1.Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, тэдгээрийн харьяа байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх;

23.1.2.худалдаа, үйлчилгээний хууль, тогтоомж, бодлого, хөтөлбөр стандарт боловсруулах, шийдвэрлүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, салбарын нэгдсэн бодлого, удирдлагаар хангаж ажиллах;

23.1.3.худалдаа, үйлчилгээний асуудлаар дэлхийн худалдааны байгууллага, олон улсын болон гадаад улс орнуудтай чөлөөт худалдааны, эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээр, 2 талт, олон талт хамтын ажиллагааны гэрээг Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээнд нийцүүлэн боловсруулж, шийдвэрлүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

23.1.4.энэ хуулийн 10.8-д заалтад холбогдох санал гаргана.

23.1.5.худалдаа, үйлчилгээ эрхлэгчид үзүүлэх төрийн үйлчилгээг нээлттэй, шуурхай хүргэх, хяналт шалгалт, бүртгэл, зөвшөөрлийн тогтолцоог боловсронгуй болгох санал боловсруулж шийдвэрлүүлэх;

23.1.5. Худалдаа, үйлчилгээний салбарт улсын төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээг удирдлагаар хангах;

23.1.6.энэ хуулийн 24.1.7-д заасан судалгааны тайланг үндэслэн салбартаа шаардлагатай хүний нөөцийн асуудлыг мэргэжлийн боловсролыг хөгжүүлэх, чадавхийг сайжруулах төлөвлөгөөг үндсэн чиглэл, хөтөлбөрт тусгуулах;

23.1.7.хуульд заасан бусад бүрэн эрх.

23.2. Худалдаа, үйлчилгээний талаарх энэ хуульд заасан төрийн зарим чиг үүргийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн төрийн бус байгууллагад шилжүүлж болно.

*24 дүгээр зүйл. Худалдаа, үйлчилгээний байгууллагын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх*

24.1.Худалдаа, үйлчилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

24.1.1.худалдаа, үйлчилгээний хууль тогтоомж, төрийн бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх, биелэлтийг Засгийн газар, Төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах;

24.1.2. худалдаа, үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журмыг энэ хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн баталж, биелэлтийг хангуулах, хууль тогтоомж, хөтөлбөр, төлөвлөгөө, төслийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх;

24.1.3.худалдаа, үйлчилгээний байгууллагын үйлчилгээний стандартыг мөрдүүлэх;

24.1.4.худалдаа, үйлчилгээний ажилтны үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах;

24.1.5.худалдаа, үйлчилгээний үйл ажиллагааны талаар гадаад улс, олон улсын болон бусад байгууллагатай Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээний дагуу хамтран ажиллах;

24.1.6. худалдаа, үйлчилгээ эрхлэгчид зориулсан үндэсний болон олон улсын үзэсгэлэн, яармаг, худалдаа, чуулга уулзалт зохион байгуулах;

24.1.7.салбарын мэргэжлийн боловсон хүчний талаарх судалгаа, чадавхыг сайжруулах асуудлын хэрэгжилтийг хангаж ажиллах;

24.1.8.хууль тогтоомжид заасан бусад.

24.2.худалдаа, үйлчилгээний сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, худалдааны чиг үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагатай үйл ажиллагаагаа уялдуулж хамтран ажиллана.

24.3.Худалдаа, үйлчилгээний төрийн байгууллагын удирдах албан тушаалтныг доор дурдсанаар томилж, чөлөөлнө:

24.3.1.худалдаа, үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргыг Худалдааны асуудал хариуцсан сайдын санал болгосноор Засгийн газар;

24.3.2.аймаг, нийслэлийн худалдаа, үйлчилгээний байгууллагын даргыг тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн худалдаа, үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга;

24.3.3.сум, дүүргийн худалдаа, үйлчилгээний асуудал хариуцсан даргыг тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн аймаг, нийслэлийн худалдаа, үйлчилгээний байгууллагын дарга.

24.4.Аймаг, нийслэлийн худалдаа, үйлчилгээний байгууллага, худалдаа, үйлчилгээний ангийн бүтцийг Засгийн газраас тогтоосон орон тооны хязгаарт багтаан худалдаа, үйлчилгээний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

24.5.Худалдаа, үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд цаг үеийн шинжтэй нөхцөл байдал үүсэхэд худалдаа,

үйлчилгээний бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, энэ хуулийн 10.4.4. заалтад тусгасан стратегийн бараанд үнийн түр зохицуулалт хийх, хэрэгжилтийг хянах үүрэг бүхий орон тооны бус зохицуулах зөвлөл ажиллана.

24.6.Худалдаа, үйлчилгээний зохицуулах зөвлөл нь мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үүрэг бүхий худалдаа, үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын ажилтан, мэргэжлийн экспертээс бүрдэнэ.

24.7.Худалдаа, үйлчилгээний зохицуулах зөвлөлийн ажиллах журмыг худалдаа, үйлчилгээний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

25 дугаар зүйл. Нутгийн өөрөө удирдах байгууллага болон Засаг даргын бүрэн эрх

25.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал худалдаа, үйлчилгээний талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

25.1.1.аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга худалдааны хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэх арга хэмжээг орон нутагт хариуцан зохион байгуулна.

25.1.2.тухайн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээг дэмжих, хөгжүүлэх орон нутгийн дэд хөтөлбөрийг бодлогын баримт бичигт нийцүүлэн боловсруулж, батлах, хэрэгжилтэд хяналт тавих.

25.1.3.худалдаа, үйлчилгээний холбогдох журмыг хуульд заасны дагуу баталж мөрдүүлэх;

25.1.4.хууль тогтоомжид заасан бусад.

## НАЙМДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦОО

*26 дугаар зүйл. Төрийн бус байгууллагын оролцоо*

26.1.Төрийн бус байгууллага худалдааны харилцаанд дараахь чиглэлээр оролцоно:

26.1.1. Худалдаа эрхлэгчийн нийтлэг эрх ашгийг хамгаалах;

26.1.2. Худалдааны чиглэлээр судалгаа хийх, санал, дүгнэлт гаргах;

26.1.3. худалдаа, үйлчилгээний ажилтныг бэлтгэх, худалдаа эрхлэгчдийн чадавхийг сайжруулах, мэргэшүүлэх сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх;

26.1.4.Экспортын барааны гарал үүслийг гэрчлэх,

26.1.5.Гадаад худалдааны гэрээ, эрх зүйн талаар мэргэжлийн зөвлөгөө өгөх;

26.1.6.худалдааны салбарт мөрдөж байгаа дүрэм, журам Худалдааны тухай хуулийг зөрчсөн гэж үзвэл түүнийг өөрчлөх, хүчингүй болгох саналыг эрх бүхий байгууллагад тавих;

26.1.7.хууль тогтоомжид заасан бусад.

*27 дүгээр зүйл. Төрийн гүйцэтгэх байгууллагын зарим чиг үүргийг шилжүүлэх*

27.1.Худалдааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараахь чиг үүргийг төрийн бус байгууллагад гэрээгээр шилжүүлж болно:

27.1.1.Худалдаа эрхлэгчийн бүртгэл, худалдааны статистик мэдээллийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах;

27.1.2.гадаад худалдаанд түгээмэл хэрэглэгддэг гэрээний үлгэрчилсэн загварыг зөвлөмж хэлбэрээр батлах;

27.1.3.худалдаатай холбогдох стандартын төсөл боловсруулах, заавал мөрдөх шинжтэй стандартын төслийг эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх;

27.1.4.худалдаанд баримтлах ёс зүйн дүрэм, зөвлөмжийг гаргах;

27.1.5.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

## ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ХУДАЛДААНЫ МЭДЭЭЛЭЛ

*28 дугаар зүйл. Худалдааны бүртгэл, статистик мэдээлэл*

28.1. Худалдааны бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим санг бүрдүүлнэ.

28.2 Улсын бүртгэл, статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага худалдаа эрхлэгчийн бүртгэл хөтөлж, худалдааны статистик мэдээллийг гаргана.

*29 дугаар зүйл. Худалдааны мэдээллийн нууц хамгаалах*

29.1.Худалдааны мэдээллийн нууцыг хамгаалахтай холбогдох харилцааг Хувь хүний нууцын тухай хууль<sup>5</sup>, Байгууллагын нууцын тухай<sup>6</sup> хуулиар зохицуулна.

## АРАВДУГААР БҮЛЭГ ХЯНАЛТ, ШАЛГАЛТ, ХАРИУЦЛАГА

*30 дугаар зүйл. Худалдааны хяналт*

30.1.Худалдаанд тавих хяналт, шалгалттай холбогдсон харилцааг Төрийн хяналт шалгалтын тухай хууль<sup>7</sup> болон холбогдох бусад хуулиар зохицуулна.

*31 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага*

31.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

31.2.Энэ хуулийг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

## АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ ХУУЛЬ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

*32 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох*

32.1.Энэ хуулийг ..... дүгээр сарын .....-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

<sup>5</sup> Хувь хүний нууцын тухайхууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1995 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

<sup>6</sup> Байгууллагын нууцын тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1995 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

<sup>7</sup> Төрийн хяналт шалгалтын тухайхууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2003 оны 2 дугаарт нийтлэгдсэн.